



“НИЖУНА” ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ  
АЛДАР СПОРТ ХОРОО

13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Л.Дандарын гудамж, Утас/Факс: (976-11) 45 24 94

2024. 05. 03 № 80

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Батлан хамгаалах яамны харьяа Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны “Б” спорт заалны шалны засварын ажил гүйцэтгүүлэх ЗХАБТСХ/202401001 дугаартай төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад ирүүлсэн уг ажлыг гүйцэтгэхээр ирүүлсэн танай тендер дараах шаардлагыг хангаагүй тул “Төрийн болон орон нутгийн өмчин хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дах заалтад заасны дагуу татгалзаж байна. Үүнд:

| №            | Тендериин баримт бичгийн заалт   | “НИЖУНА” ХХК-ийн ирүүлсэн тендер   |
|--------------|--|--|
| ТЗШ<br>15.6  | <p><b>Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:</b></p> <p>Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих жилийн тоо: 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгөөс багагүй үнийн дүнтэй спортаа заалны шалны засварын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх.</p> <p>Ажил гүйцэтгэсэн гэрээ, комисс хүлээж авсан дүгнэлтийн эхээс хийсэн хуулбар (Комиссын дүгнэлт нь Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоолын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан баталгаажуулсан байна.)</p> | <p>Ижил төстэй ажлын туршлага нь спорт заалны шалны засварын ажил хийж гүйцэтгэгчээр ажилласан байх шаардлагад нийцээгүй.</p> <p>“Алдар” спорт хорооны “Б” спорт зааланд нэг ээлжид 40-50 өсвөрийн тамирчид 3-н ээлжээр, ЗХ-ний алба хаагчид батлагдсан цагийн хуваарийн дагуу бэлтгэл, сургуулилт хийдэг. Ажлын туршлагагүй байгууллагаар ажил гүйцэтгүүлэх нь алба хаагч, тамирчдын гэмтэл бэртэл учруулах эрсдэлтэй гэж үзэж байна.</p> |
| 3 бүлэг<br>6 | <p><b>Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага:</b></p> <p>Ажлын талбайтай танилцсан тэмдэглэлийг фото зургийн хамт ирүүлнэ.</p>   | Ажлын талбайтай танилцсан тэмдэглэл, фото зургийн хамт ирүүлээгүй нь шаардлагад нийцээгүй.   |

132803014

Уг тендерт шалгаруулалтад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах болсныг мэдэгдье.

